

2023 он

# Шүүх хурал хойшлох шалтгаан, нөхцөлийг тодруулах нь

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Гүйцэтгэсэн: З.Баянсүрэн  
(Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төвийн  
Социологич-судлаач)



# “Шүүх хурал хойшлох шалтгаан, нөхцөлийг тодруулах нь”

---

судалгааны тайлан



Улаанбаатар  
2023 оны 8 сар



## АГУУЛГА

Хүснэгт, дүрсийн жагсаалт .....	3
Хураангуй.....	5
Судалгааны зорилго, судалгааны арга зүй .....	7
Арга зүй.....	7
Судалгааны түүвэр .....	8
1.    Онлайн судалгааны үр дүн.....	10
1.2 Шүүх хуралдаан хойшлоход нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг тодорхойлох.....	12
1.2 Шүүх хуралдаан хойшлоход үүсэх үр дагаврыг тодорхойлох.....	20
2.    Цаасан суурьт судалгааны үр дүн.....	24
2.1 Шүүх хуралдаан хойшлоход нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг тодорхойлох.....	26
2.2 Шүүх хуралдаан хойшлоход үүсэх үр дагаврыг тодорхойлох.....	35
ДҮГНЭЛТ.....	39
ЗӨВЛӨМЖ.....	41





## ХҮСНЭГТ, ДҮРСИЙН ЖАГСААЛТ

График 1. Судалгаанд оролцогчдын нас.....	9
График 2. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдал болон хүйсийн харьцаа.....	9
График 3. Та шүүхээр үйлчлүүлж байсан уу?.....	10
График 4. Тухайн шүүх хуралдаан хэдэн удаа хойшилсон бэ? .....	10
График 5. Та шүүхээр хэзээ хамгийн сүүлд үйлчлүүлсэн бэ? .....	11
График 6. Шүүх хуралд оролцсон талууд.....	12
График 7. Аль шатны шүүхээр үйлчлүүлэхэд шүүх хуралдаан хойшилж хүндрэл учруулж байсан бэ? .....	12
График 8. Шүүх хурал хойшилж хүндрэл үүсгэж байсан эсэхийг шүүхийн шатлал болон маргааны төрлөөр харуулав .....	13
График 9. Тухайн шүүх таны асуудлыг хэдий хугацаанд шийдвэрлэж өгсөн бэ? .....	13
График 10. Шүүх хуралдааныг хойшлуулахад Танд хэр хүндрэл үүссэн бэ? .....	14
График 11. Эрүүгийн хэргийн шүүх хуралдаан хойшилсон шалтгаануудыг харуулав. ....	14
График 12. Захиргааны хэргийн шүүх хуралдаан хойшилсон шалтгааныг харуулав. , .....	18
График 13. Та шүүх хуралдааныг хойшлуулах шаардлагагүй үргэлжлүүлэх нь зөв байсан гэж бодож байсан уу? .....	20
График 14. Шүүх хуралдааныг хойшлуулах шаардлагагүй үргэлжлүүлэх нь зөв байсан эсэх асуумжийг судалгаанд оролцогчдын боловсролын түвшнээр харвал .....	22
График 15. Шүүх хуралдаан хойшилсноор ямар сөрөг үр дагавар үүснэ гэж Та үзэж байна вэ? .....	22
График 16. Судалгаанд оролцсон иргэдийн тоог байршлаар нь харуулав. ....	24
График 17. Тухайн шүүх хуралдаан одоогийн байдлаар хэдэн удаа хойшилсон бэ? .....	24
График 18. Судалгаанд оролцогчдын нас.....	25
График 19. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин, эрх зүйч мэргэжилтэй эсэх болон хүйсийн харьцаа.....	25
График 20. Шүүх хуралд оролцсон талууд.....	26
График 21. Шүүх хурал хойшилж хүндрэл үүсгэсэн эсэхийг шүүхийн шатлал болон маргааны төрлөөр харуулав .....	27
График 22. Тухайн хэрэг маргаан нь шүүхэд хандсанаас хойш эцэслэн шийдвэрлэгдэхгүй хэр удаж байна вэ? /n=625/.....	27
График 23. Шүүх хуралдаан хойшилсноор иргэдэд үүсч буй хүндрэлийг харуулав.....	28
График 24. Шүүх хуралдаан хойшилсноор иргэдэд үүсч буй хүндрэлийн төвшнийг хүйсээр харьцуулан харуулав. ....	28
График 25. Эрүүгийн хэргийн шүүх хуралдаан хойшилсон шалтгаануудыг харуулав. (n=597 давтагдсан утга) .....	29
График 26. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулсан хугацааг хэргийн зүйчлэлээр харуулав .....	31
График 27. Иргэний хэргийн шүүх хуралдаан хойшилсон шалтгааныг харуулав. ,(n=925 давтагдсан утга).....	31
График 28. Захиргааны хэргийн шүүх хуралдаан хойшилсон шалтгааныг харуулав. ....	32



График 29. Та шүүх хуралдааныг хойшлуулах шаардлагагүй үргэлжлүүлэх нь зөв байсан гэж бодож байсан уу? ..... 35

График 30. Шүүх хуралдааныг хойшлуулах шаардлагагүй үргэлжлүүлэх нь зөв байсан эсэх асуумжийг судалгаанд оролцогчдын боловсролын түвшнээр харвал ..... 36

График 31. Шүүх хуралдааныг хойшлуулах шаардлагагүй үргэлжлүүлэх нь зөв байсан эсэх асуумжийг судалгаанд оролцогчдын хүйсээр харвал ..... 37

График 32. Шүүх хуралдааныг хойшлуулах шаардлагагүй үргэлжлүүлэх нь зөв байсан эсэх асуумжийн хувилбар тус бүрийг хүйсээр харвал..... 37

График 33. Шүүх хуралдаан хойшилсноор ямар сөрөг үр дагавар үүснэ гэж Та үзэж байна вэ? ..... 37





## ХУРААНГУЙ

Шүүхийн байгууллагын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанарыг хэмжих нэгэн хэмжүүр бол хэргийг шийдвэрлэж буй хугацаа билээ. Уг хугацаа нь шүүх хурал хэдэн удаа хойшлохоос шууд хамааралтай .

Нөгөө талаас шүүхээс хэргийг хянан шийдвэрлэх явцад хэргийн ээдрээ төвөгтэй байдал, хэргийн оролцогчийн тоо олон байх зэрэг нөхцөл байдлаас болж шүүх алдаа мадаггүй шийдвэр гаргахын тулд олон дахин хойшлох тохиолдол гарах нь зүй ёсны асуудал юм.

Гэвч хэрэг удаашрах тусам хэргийн оролцогч нарт ялангуяа нэхэмжлэгч, хохирогч талд хөрөнгө мөнгө, цаг хугацаа, сэтгэл санааны тайван байдлаа алдах зэрэг сөрөг асуудлууд үүсдэг бөгөөд шүүхийн хувьд ч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой зардал нэмэгддэг. Үүнтэй холбоотойгоор олон нийтийн дунд шүүх хуралдааныг аль нэг талын хэргийн холбогдогч нарт ашигтай байдлаар хойшлуулсан гэх хардлага үүсэх, шүүхэд итгэх иргэдийн итгэл буурах зэрэг олон сөрөг нөлөөтэй. Жишээлбэл, 2018 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн Өдрийн сонин №178 (6021) нийтлэгдсэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн дарга Х.Билгүнзаяагийн өгсөн “Шүүх хэн нэгний талд орж хуралдааныг хойшлуулах боломж байхгүй” гэсэн гарчигтай ярилцлагад Ноён уулын маргаантай холбоотой хэрэг 39 дэх удаагаа хойшилсон кэйс байсан бөгөөд тус хэргийн хувьд хойшилсон шалтгаан нь “Хэргийн оролцогчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрх эдэлж, үүрэг хүлээдэг. Шүүхээс мөн хэргийн оролцогчдын хуульд заасан эрхийг хангах үүрэгтэй. Ийм хуультай. Үүний дагуу хэргийн оролцогчдын зүгээс шүүхэд тодорхой хүсэлтүүдийг гаргаж шүүх тухай бүр нь шийдвэрлэж ирсэн. Тэд шүүх хүлээж авахаас өөр аргагүй хүсэлтийг гаргахаа бас сайн мэддэг. Энэ нь шүүх хуралдаан олон дахин хойшлох үндэслэл шалтгаан болсон байна.”<sup>1</sup> гэжээ. Үүнээс харахад хууль эрх зүйн мэдлэг өндөртэй хэргийн оролцогч болон түүний өмгөөлөгч нар хэргийг удаашруулах, цаг хугацаа хожих гэх мэт өөрт ашигтай байдлыг бий болгодог гэсэн хардлага үүсэж байна.

Шүүх хуралдаан олон дахин хойшилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах нь олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг сулруулах, шүүхийн зардлыг нэмэгдүүлэх сөрөг талтай учир шүүхийн байгууллага боломжит түргэн шуурхай шийдвэрлэх арга замыг эрэлхийлж байх нь зүйтэй.

Монгол Улсын шүүх Rule of Law Index буюу Эрх зүйг дээдлэх индексээр Монгол Улс дэлхийд 2015-2022 он хүртэлх хугацаанд ерөнхий оноог харахад дунджаар 0.53 оноо авч, 140 орноос 62-д эрэмбэлэгдэж байна.<sup>2</sup> Дэлхийн бусад улс орны хэмжээнд шүүхийн үйлчилгээний чанар нь улсын төсөвтэй шууд хамааралтай тул шүүхийн төсвийг үр ашигтай зарцуулж, зардлыг багасгах асуудлыг олж, шийдвэрлэх хэрэгтэй юм.

<sup>1</sup> (<https://dnn.mn/%D1%85-%D0%B1%D0%B8%D0%BB%D0%B3%D2%AF%D0%BD%D0%B7%D0%B0%D1%8F%D0%B0-%D1%88%D2%AF%D2%AF%D1%85-%D1%85%D1%8D%D0%BD-%D0%BD%D1%8D%D0%B3%D0%BD%D0%B8%D0%B9-%D1%82%D0%B0%D0%BB%D0%B4-%D0%BE%D1%80%D0%B6-%D1%85%D1%83%D1%80%D0%B0%D0%BB%D0%B4%D0%B0%D0%B>, 2018)

<sup>2</sup> (<https://worldjusticeproject.org/rule-of-law-index/>, 2023)



Иймд Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв нь энэхүү асуудлын хүрээнд шүүх хуралдаан хойшилж, удааширдаг шалтгаан нөхцөлийг илрүүлж, түүнээс үүсэх үр дагавар хэргийн оролцогч нарт ямар хүндрэл бэрхшээл учруулдаг болохыг тодорхойлж уг хүндрэл бэрхшээлийг бууруулах зорилготойгоор “Шүүх хуралдаан хойшилсон шалтгаан, нөхцөлийг тодруулах нь” сэдэвт олон нийтийн санал бодолд тулгуурласан судалгааг хийж та бүхэнд толилуулж байна.





## СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү судалгаагаар шүүх хуралдаан хойшилж, удааширдаг шалтгаан нөхцөлийг илрүүлж, түүнээс үүсэх үр дагавар хэргийн оролцогч нарт ямар хүндрэл бэрхшээл учруулж байгааг тодорхойлон түүнийг бууруулахад шаардлагатай арга хэмжээний санал, зөвлөмж гаргах зорилготой юм.

Зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

- i. Шүүх хуралдаан хойшлоход нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг тодорхойлох;
- ii. Шүүх хуралдаан хойшлоход үүсэх үр дагаврыг тодорхойлж, сайжруулах санал, зөвлөмжийг гаргах гэсэн зорилтууд багтана.

### АРГА ЗҮЙ

Суурь судалгаа нь зураг 1-д үзүүлсэнчлэн үндсэн гурван үе шатаас бүрдэнэ.

#### Зураг 1. Судалгааны үйл явц



Судалгааны сэдвийн хүрээнд өмнө нь хийгдэж байсан судалгаа, шинжилгээний ажил байгаа эсэхийг судлан тус судалгааны зорилго, зорилт болон судалгааны арга зүй зэргийг нарийвчлан тодорхойлж, асуумжийг боловсруулах ажлыг бэлтгэл үе шатны хугацаанд хийж гүйцэтгэлээ. Судалгааны асуумж нь шаардлагатай мэдээллийг хамгийн бага алдааны түвшинд, үр ашигтай цуглуулах боломжийг олгодог. Иймд асуумжыг боловсруулахын тулд олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжийг судалж, түүнтэй уялдуулан боловсруулсан болно.

Судалгааны мэдээллийг цуглуулахдаа компьютерт суурилсан мэдээлэл цуглуулалтын арга болон цаасан дээр суурилсан анкетаар авсан болно.

Цугларсан өгөгдлийг боловсруулалт хий дата анализ хийхэд боломжтой байдлаар хувиргаж, дүн шинжилгээ хийж, суурь судалгааны эцсийн тайланг боловсрууллаа.





## СУДАЛГААНЫ ТҮҮВЭР

Судалгааг 2023 оны 06 сарын 23-ны өдрөөс 2023 оны 08-р сарын 10-ны өдрийн хугацаанд онлайнаар нийт 106 иргэн, харин цаасан суурьтай асуумжийг ашиглан дараах зорилтот буюу нийслэлийн төвийн дүүргийн шүүхийн Тамгын газраар үйлчлүүлж буй хүмүүсээс 730 иргэнийг судалгаанд хамруулсан байна. Тодруулбал;

- Нийслэл захиргаа анхан-124 иргэн;
- БГД,ХУД,СХД-ын ЭХАШШ-112 иргэн;
- БЗД-ын ИХАШШ-39 иргэн;
- СБД,ЧД-ын ИХАШШ-182 иргэн;
- СХД-ын ИХАШШ-28 иргэн;
- БЗД,СБД,ЧД-ын ЭХАШШ-139 иргэн;
- БГД,ХУД-ын ИХАШШ-106 иргэн тус тус хамрагдсан байна.






## 1.1 ОНЛАЙН СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэхүү дэд бүлэгт онлайн судалгаанд оролцогчдийн ерөнхий мэдээллийг задлан харуулав.

График 1. Судалгаанд оролцогчдын нас



Онлайнаар нийт 106 иргэн оролцож үүнээс 25-44 насны иргэд дийлэнх хувийг эзэлж байна.

График 2. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин, ажил эрхлэлтийн байдал болон хүйсийн харьцаа







График 2-оос харахад судалгаанд хамрагдсан оролцогчдын 60 хувь нь бакалавр болон дипломын дээд боловсролтой, 24 хувь нь магистр болон түүнээс дээш зэрэгтэй, 9 хувь нь бүрэн дунд боловсролтой байгаа бол үлдсэн 7 хувь нь тусгай дунд, бүрэн бус дунд, хариулахаас татгалзсан гэх хариултыг өгсөн байна. Үүнээс харахад судалгаанд оролцож буй иргэдийн боловсролын түвшин харьцангуй өндөр байгааг харуулж байна.

Ажил эрхлэлтийн байдлын хувьд нийт оролцогчдын 35 хувь нь хувийн байгууллагад, 34 хувь нь төрийн болон төсвийн байгууллагад ажилладаг.

Энэхүү судалгаанд хүйсийн тэнцвэрт ойролцоо буюу 53 хувь нь эмэгтэй, 47 хувь нь эрэгтэйчүүд байна.

## 1.2 ОНЛАЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

График 3. Та шүүхээр үйлчлүүлж байсан уу?



Судалгаанд оролцсон нийт иргэдийн 81.4 хувь (n=83) нь шүүхээр үйлчлүүлж байсан бол үлдсэн 18.6 хувь (n=19) нь үйлчлүүлж байгаагүй байна.

График 4. Тухайн шүүх хуралдаан хэдэн удаа хойшилсон бэ?




График 5-аас харахад шүүхээр үйлчлүүлж байсан иргэдийн дийлэнх нь буюу 82 хувь нь хойшилсон гэж хариулсан бөгөөд хэдэн удаа хойшилж байсныг задлан харахад 2-3 удаа хойшилдог гэсэн хариултыг хамгийн олон хүн буюу нийт



оролцогчдын 34 хувь нь сонгосон бол 1 удаа хойшилсон гэсэн хариултыг 24 хувь нь хойшилж байсан гэж хариулснаас харахад шүүх хурал дор хаяж 2-3 удаа хойшлох магадлал өндөр байна.

Судалгаанаас 14 хоногийн дотор шүүхэд хандсан хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхэд 2-3 удаа хойшилсон маргаан нь сонирхол татаж байв. Тус хэрэг маргаан нь бүгд иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандсан 3 хэрэг байсан бөгөөд хурал хойшилсон шалтгаануудыг харахад өмгөөлөгч авах хүсэлт гаргасан, хэргийн оролцогчид нотлох баримт гаргуулах хүсэлт гаргасан, шүүх хуралдаанд шинжээч ирээгүй, нотлох баримт гаргуулах хүсэлт гаргасан, нэхэмжлэлийн шаардлагаа нэмсэн буюу өөрчилсөн гэсэн байна. Үүнээс харахад иргэн шүүхийн журмаар асуудлаа шийдвэрлүүлэхэд цаг хугацаа маш их зарцуулдаг болох нь харагдаж байна.

Баримт бичгийн шинжилгээ хийхэд Хадгаламж банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагч (БЭХА)-аас 2013 оны 7-р сарын 22-ны өдрөөс 2019 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд барагдуулсан нийт 660 (зургаан зуун жаран) чанаргүй актив (зээл, авлага)-ын мэдээллийг ашигласан гүйцэтгэсэн судалгаанд банкнаас нийт чанаргүй зээлд шүүхээр шийдвэрлүүлсэн зээлийн хувийг тооцож гаргасан байна. Тус судалгаагаар шүүхийн журмаар<sup>3</sup> шийдвэрлүүлсэн зээлийн хэмжээ 64 хувийг эзэлж байгаа бол шүүхийн бус журмаар<sup>4</sup> 36 хувь нь шийдвэрлүүлсэн байна. Хугацааны хувьд шүүхийн журмаар шийдвэрлүүлэхэд дунджаар 6.2 жил шаардагдаж байгаа бол шүүхийн бус журмаар үүнээс хоёр дахин бага хугацаа буюу 3.4 жил зарцуулагдаж байна. Энэ нь активын хэлбэрийн хувьд мөн ижил хандлагатай байгаа бөгөөд шүүхийн журмаар барагдуулахад вексель, зээл аль аль нь урт хугацаа шаардаж байна гэжээ.<sup>5</sup>

**График 5. Та шүүхээр хэзээ хамгийн сүүлд үйлчлүүлсэн бэ?**




График 5-аас харахад судалгаанд оролцогчдын 2 хүн тутмын 1 нь энэ сард шүүхээр үйлчлүүлсэн байна.

<sup>3</sup> Шүүхэд нэхэмжлэл гаргаж, зээлийн төлбөрийг шаардах.


<sup>4</sup> Шүүхэд нэхэмжлэл гаргалгүйгээр, эсхүл шүүхээр шийдвэрлүүлэх хугацаанд зээлдэгчтэй тохиролцох, эвлэрэх зэргээр зээлийн төлбөрийг барагдуулах.

<sup>5</sup> “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл, 2020 оны 21-р дугаар, “Чанаргүй зээлийн барагдуулалт /Хадгаламж банк ХХК-ийн жишээ/”, хуудас-45.

### 1.2.1 ШҮҮХ ХУРАЛДААН ХОЙШЛОХОД НӨЛӨӨЛЖ БУЙ ШАЛТГААН НӨХЦӨЛИЙГ ТОДОРХОЙЛОХ


Энэ бүлэгт шүүх хуралдаан хойшлоход нөлөөлж буй шалтгаан нөхцөлийн хүрээнд шүүх хуралдаан хойшлоход аль шатны, ямар төрлийн хэрэг, маргаан, хэр их хүндрэл үүсгэж байгааг хэмжих болно. Учир нь эрүү, иргэн, захиргааны хэрэг маргаан нь өөр өөрийн онцлогтой байдаг тул тэдгээрийн хурал хойшлох шалтгаануудыг тус бүрээр нарийвчлан задалж харуулна.

**График 6. Шүүх хуралд оролцсон талууд**



Шүүхээр үйлчлүүлсэн иргэдийг шүүх хуралдаанд ямар байдлаар оролцож байсныг задлан харвал олонх нь буюу 35 хувь нь нэхэмжлэгч, 19 хувь нь итгэмжлэгдсэн төлөөлөгч, 12 хувь нь өмгөөлөгчөөр оролцсон байна.

**График 7. Аль шатны шүүхээр үйлчлүүлэхэд шүүх хуралдаан хойшилж хүндрэл учруулж байсан бэ?**




Шүүх хурал хойшилж байсан гэж хариулсан иргэдийн хувьд анхан шатны шүүх дээр хүндрэл үүсч байсан гэж тус оролцогчдын 85 хувь нь хариулсан бөгөөд харин 13 хувь нь хүндрэл үүсэж байгаагүй гэж хариулжээ.

Дараах график 8-д шүүх хуралдаан хойшилж, хүндрэл үүсгэсэн эсэхийг шүүхийн шатлал болон хэрэг хянан шийдвэрлэх төрлөөр задлан харвал:



**График 8. Шүүх хурал хойшилж хүндрэл үүсгэж байсан эсэхийг шүүхийн шатлал болон маргааны төрлөөр харуулав**



Шүүх хурал нь хойшилж байсан нийт 68 оролцогчоос 63% нь иргэний хэргийн анхан шатны шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн 63%-д нь, захиргааны хэргийн анхан шатны шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн 6%-д, эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн 13%-д харин зөрчлийн хэргийн хувьд 1%-д нь хүндрэлтэй байдал үүсгэсэн байна.

Харин иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Улсын дээд шүүхийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд шүүх хуралдааны явцад шүүх хурал хойшилж хүндрэл үүсгэсэн гэж тус тус оролцогчдын 1% нь хариулсан байна.

**График 9. Тухайн шүүх таны асуудлыг хэдий хугацаанд шийдвэрлэж өгсөн бэ?**





График 9-өөс харахад эдгээр шүүхэд хандаж байсан оролцогчдын олонх нь буюу 26 хувь нь 1-2 сарын хугацаанд, 18 хувь нь 3-5 сарын хугацаанд асуудлаа шийдвэрлүүлсэн байна. Харин хамгийн урт хугацаа болох 3 жил гэсэн хариултыг тус оролцогчдын 1 хувь нь сонгожээ.

Мөн зөрчлийн хэргийг өдөрт нь шийдвэрлэдэг гэж 3 хувь нь хариулсан байна.



**График 10. Шүүх хуралдааныг хойшлуулахад Танд хэр хүндрэл үүссэн бэ?**



Шүүх хурал хойшлох нь иргэдийн хувьд хөрөнгө мөнгө, цаг хугацаа, сэтгэл санааны тайван байдлаа алдах зэрэг сөрөг асуудлуудыг үүсдэг байна. Тухайн шүүх хурал хойшилсон нь тэдний хувьд хэр хүндрэлтэй санагддаг болохыг үнэлүүлэхэд дийлэнх хувь нь хүндрэл үүссэн гэж хариулсан ба үүний 18 хувь нь маш их хүндрэл үүссэн, 16 хувь нь их хүндрэл үүссэн, 25% нь тодорхой хэмжээнд хүндрэл үүссэн гэжээ.

**График 11. Эрүүгийн хэргийн шүүх хуралдаан хойшилсон шалтгаануудыг харуулав.<sup>6</sup>**



<sup>6</sup> Цэнхэр өнгөөр-Шүүх хуралд оролцогч талуудтай, ногоон өнгөөр шүүх болон хууль зүйн байгууллагуудтай хамааралтай харин шар өнгөөр зөвхөн өмгөөлөгчтэй холбоотой шалтгаануудыг тэмдэглэв.





Дээрх 11 дүгээр графикт эрүүгийн хэргийн шүүх хурал ямар шалтгааны улмаас хойшилсон болохыг харуулав. Нийт шалтгааны дийлэнх хувийг өмгөөлөгч авах хүсэлт гаргасан, өмгөөлөгч солигдож, эсхүл нэмэгдэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох болсон удаах нь хэргийн материалтай танилцах хүсэлт гарсан гэсэн шалтгаан эзэлж байна.

Нийт 20-н шалтгааныг шүүх хуралд оролцогч талуудаас шалтгаалсан, шүүх болон хууль зүйн байгууллагуудтай хамааралтай болон зөвхөн өмгөөлөгчтэй холбоотой гэж 3 хэсэгт өнгөөр ялган харуулав. Үүнд:

Шүүх хуралд оролцогч талуудтай холбоотой шалтгааныг тодруулж харвал.

- Шүүх хурлын **52.5 хувь нь шүүх хуралд оролцогч талуудаас шалтгаалж хойшилсон** бөгөөд үүнээс хамгийн их хувийг эзэлж байгаа 3 шалтгаанаар хэргийн материалтай танилцах хүсэлт гарсан, хэргийн оролцогчид нотлох баримт гаргуулах хүсэлт гаргасан, шүүгчээс татгалзах тухай хүсэлт гаргасан шалтгааныг нэрлэсэн байна.

Шүүх болон хууль зүйн байгууллагуудтай холбоотой шалтгааныг харвал.

- Шүүх хурлын **14.8 хувь нь шүүх болон хууль зүйн байгууллагуудтай холбоотой асуудлаас болж хойшилсон** байна. Үүнээс хамгийн их хувийг эзэлж байгаа 3 шалтгааныг дурдвал улсын яллагч солигдож, эсхүл нэмэгдэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох болсон, прокурор шүүх хуралдаанд ирээгүй, хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдээгүй гэсэн шалтгаанууд байна.

Зөвхөн өмгөөлөгчтэй холбоотой шалтгааныг харвал.

- Өмгөөлөгч авах хүсэлт гаргасан, өмгөөлөгч өвчтэй, өмгөөлөгч солигдож, эсхүл нэмэгдэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох болсон гэх 3 шалтгаанаар шүүх хурлын **32.7 хувь нь** хойшилдог байна.

### Хүснэгт 1. Шүүх хурал хойшлуулах шалтгаанаас огт сонгогдоогүй шалтгаануудыг харуулав

Шүүх хуралдааны техник хэрэгсэлд саатал гарсан
Хэргийн зохигч сэтгэцийн болон бусад хүнд өвчний улмаас хүрэлцэн ирж чадахгүй
Орон байранд үзлэг хийхийг талууд харилцан зөвшөөрсөн
Шүүгч өөрөө татгалзан гарах тухай хүсэлт гаргасан
Шүүх хуралдааны тог тасарсан (хэргийн оролцогчдын хэн нэгэн зайнаас буюу цахимаар оролцох үед)
Яллагдагчийн хаана байгаа нь мэдэгдэхгүй байх
Шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлсэн

Судалгаанд оролцогчид нийт 27 шалтгаанаас дээрх хүснэгт 1-ээр харуулсан 7 шалтгааныг огт сонгоогүй байна.



График 13. Иргэний хэргийн шүүх хуралдаан хойшилсон шалтгааныг харуулав. <sup>7,8</sup>

График 15-аас харахад нийт 20 шалтгаанаар иргэний хэргийн шүүх хуралдаан хойшилсон ба үүнээс хэргийн материалтай танилцах хүсэлт гаргасан, өмгөөлөгчийн

<sup>7</sup> ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.8-д заасан үндэслэл (Томилогдсон иргэдийн төлөөлөгч энэ хуулийн 76.1.2-т заасны дагуу мэдэгдсээр байхад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол зохигчийн зөвшөөрлөөр түүний эзгүйд шүүх хуралдаан явуулж болно. Харин зохигчийн аль нэг нь үүнийг зөвшөөрөөгүй бол шүүх хуралдааныг хойшлуулна.

<sup>8</sup> **Цэнхэр өнгөөр**-Шүүх хуралд оролцогч талуудтай, **ногоон өнгөөр** шүүх болон хууль зүйн байгууллагуудтай хамааралтай харин **шар өнгөөр** зөвхөн өмгөөлөгчтэй холбоотой шалтгаануудыг тэмдэглэв.



хурал давхардсан, өмгөөлөгч авах хүсэлт гаргасан гэсэн 3 шалтгаан хамгийн их хувийг эзэлж байна. Харин үүнийг шүүх хуралд оролцогч талуудаас шалтгаалсан, шүүх болон хууль зүйн байгууллагуудтай хамааралтай болон зөвхөн өмгөөлөгчтэй холбоотой гэсэн 3 хэсэгт задалж харвал. Үүнд:

Шүүх хуралд оролцогч талуудтай холбоотой шалтгааныг тодруулж харвал.

- Шүүх хурлын **55 хувь нь шүүх хуралд оролцогч талуудаас шалтгаалж хойшилсон** бөгөөд үүнээс хамгийн их хувийг хэргийн материалтай танилцах хүсэлт гарсан, нотлох баримт гаргуулах хүсэлт гаргасан, нэхэмжлэлийн шаардлагаа нэмсэн буюу өөрчилсөн хүсэлт гаргасан 3 шалтгаан эзэлж байна.

Шүүх болон хууль зүйн байгууллагуудтай холбоотой шалтгааныг харвал.

- Шүүх хурлын **9 хувь нь шүүх болон хууль зүйн байгууллагуудтай холбоотой асуудлаас болж хойшилсон** байна. Үүнээс хамгийн их хувийг эзэлж байгаа 3 шалтгааныг дурдвал шүүх хуралдааны тов мэдэгдээгүй, шүүх хурлын танхим хүрэлцээгүй, гэрлэгчдийн хэн нэг нь хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй байна.

Зөвхөн өмгөөлөгчтэй холбоотой шалтгааныг харвал.

- Шүүх хурлын **36 хувь нь өмгөөлөгчтэй холбоотой асуудлаар хойшилсон** байна. Үүнийг задалж харвал 14.4 хувь нь өмгөөлөгчийн хурал давхардсан, 13,9 хувь нь өмгөөлөгч авах хүсэлт гаргасан үлдсэн 7.2 хувь нь өмгөөлөгч өвчтэй гэсэн байна.

Иргэний хэргийн хувьд тухайн нэг шүүх хуралдааныг хойшлуулах шаардлагагүй байсан гэж үзсэн оролцогчийн тайлбарыг шигтгээ хэлбэрээр оруулав.

### **Шигтгээ 1. Шүүх хуралдаан хойшлуулах шаардлага байгаагүй гэж үзсэн судалгааны оролцогч**

“Хойшлуулах шаардлага гарч болно, гэхдээ иргэний хэрэгт ялангуяа шүүгч хугацаа удааширч байгаад тэгтлээ стресс өгөх хэрэггүй. Учир нь аль аль талын хүсэлт, санаачилгаар явдаг процесс. Шүүх хурал хойшлуулах хугацааг мөнгөтэй уяж эсвэл системээрээ цэгцлэх ёстой болохоос процесс удааширлаа гээд хэн нэг өмгөөлөгчийг/шүүгчийг буруутгаад байх өрөөсгөл. Удах тусам, хүсэлт, тайлбар нэмж гаргах бүрт мөнгө төлдөг болох хэрэгтэй. Тэгж байж хүн бүр шүүх дээр очоод байхгүй учраа олдог болно, шүүхийн ачаалал ч буурна, эцэст нь чанар ч яригдана. Үгүй бол шүүхийг хугацаа хожих шалтгаан болгож ашиглах явдал ч байна. Энэ нь бизнес талаасаа ийм тактик байхыг ч буруутгах боломжгүй. Хэрэв тийм тактиктэй байгаа бол шүүхэд болон улсад ажил хийлгэж байгаа мөнгийг нь төлдөг байх хэрэгтэй. Шүүх бүх л улсад уддаг, систем процесс тийм л байдаг. Хуулийн үндэслэл, үйл баримт нь байвал хойшилж л таарна. Гэхдээ энэ бүрт систем нь хугацааг барих ёстой болохоос шүүгч биш. Хоёр талын санаачилгаар явж байгаа процесс удаашрахад шүүгч стресстэйд байгааг/шүүгчээ стресст оруулаад байгааг ойлгохгүй байна. Миний бодлоор хурал хойшлох шалтгааныг буруу өнцгөөс хайгаад байх шиг санагдаж байна.”

**Эх сурвалж: Онлайн судалгааны оролцогч**



Мөн судалгааны хүрээнд социал орчин дахь баримт бичгийн судалгаанаас дараах шийдлийг оруулав.

“Шийдэл бол онцгой ажиллагааны журмаар гаргасан Хүсэлтийг шүүх хуралдаан хийхгүйгээр шийдэж болох зохицуулалт юм. Тодруулбал, шүүгч баримттай танилцаад хүсэлтийг хангах үндэслэлтэй, хангалттай баримт цугларсан гэж үзвэл шүүх хуралдаан хийхгүйгээр шийдвэр гаргах боломжтой байдлаар хуульчилж болно. Одоо бол заавал шүүх хуралдаан хийх зохицуулалттай. Хуралдаан хийхгүй байснаар нарийн бичиг ажиллахгүй, тэмдэглэл хөтлөхгүй, шүүгч хуралд цаг зарцуулахгүй, тэмдэглэл уншиж суухгүй, заалны ачаалал буурна. Хүсэлтийг хангаж байгаа учир Хүсэлт гаргагч гомдоод байх зүйлгүй. (Онцгой ажиллагаанд хариуцагч, маргалдагч тал байхгүй учир мэтгэлцэх зарчим хэрэгждэггүйг бас санах хэрэгтэй) Бас хүсэлт гаргагч ч шүүхэд очих, хүлээх, хуралд суух цагаа хэмнэнэ. (Жич: Харин баримт дутуу, тодруулах шаардлагатай гэж үзвэл эсвэл хурлаар шийднэ гэж шүүгч өөрөө үзвэл хурал хийж болно) Одоо бол хариуцагчийг эрэн сурвалжлуулах хүсэлт өгсөн ч, бүх баримт нь хангалттай байсан ч хуралдаанаар шийдэх зохицуулалттай. Энэ бол шүүхэд зохиомол ачаалал үүсгэсэн, шүүхийн бүтээмжийг бууруулсан зохицуулалт. Иймд үүнийг халах хэрэгтэй.

**Эх сурвалж: Хуульч А.Базар /цахим хуудаснаас авав/**

## Хүснэгт 2. Шүүх хурал хойшлуулах шалтгаанаас огт сонгогдоогүй шалтгаануудыг харуулав

ИХШХШТХ-ийн 90 дүгээр зүйлийн 90.5-д заасан үндэслэл (Зөрчлийн улмаас хэргийн оролцогч, гэрч, шинжээчийг шүүх хуралдааны танхимаас гаргасан тохиолдолд шүүх хуралдааныг хуралдаан даргалагчийн захирамжаар тодорхой хугацаагаар хойшлуулах

Шүүх хуралдааны тог тасарсан (хэргийн оролцогчдын хэн нэгэн зайнаас буюу цахимаар оролцох үед

Харин нийт 22 хойшлуулах шалтгаанаас дараах шалтгаануудыг огт сонгоогүй 2 шалтгааныг дээрх хүснэгт 2-оор харуулав.

## График 12. Захиргааны хэргийн шүүх хуралдаан хойшилсон шалтгааныг харуулав.

<sup>9 10</sup>

<sup>9</sup> ЗХХШТХ-ийн 74 дүгээр зүйлийн 74.2-т заасан “...нэмэлт нотлох баримт цуглуулах, гэрчийн мэдүүлэг авах, шинжээч томилуулах”, ЗХХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.7-д заасан “...шинээр нотлох баримт зайлшгүй шаардагдвал”, ЗХХШТХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.2-т заасан “Нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч шүүх хуралдаанд ирээгүй”.

<sup>10</sup> Цэнхэр өнгөөр-Шүүх хуралд оролцогч талуудтай, ногоон өнгөөр шүүх болон хууль зүйн байгууллагуудтай хамааралтай харин шар өнгөөр зөвхөн өмгөөлөгчтэй холбоотой шалтгаануудыг тэмдэглэв.




График 12-оос харахад захиргааны хэргийн шүүх хуралдаан хойшилсон 23 шалтгаанаас өмгөөлөгчийн хурал давхацсан, өмгөөлөгч авах хүсэлт гаргасан, өмгөөлөгч өвчтэй гэсэн хариултууд хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Харин үүнийг шүүх хуралд оролцогч талуудаас шалтгаалсан, шүүх болон хууль зүйн байгууллагуудтай хамааралтай болон зөвхөн өмгөөлөгчтэй холбоотой гэсэн 3 хэсэгт задалж харвал. Үүнд:



Шүүх хуралд оролцогч талуудтай холбоотой шалтгааныг тодруулж харвал.

- Шүүх хурлын **58.1 хувь нь шүүх хуралд оролцогч талуудаас шалтгаалж хойшилсон** бөгөөд үүнээс хамгийн их хувийг ЗХХШтХ-ийн 74 дүгээр зүйлийн 74.2-т заасан “...нэмэлт нотлох баримт цуглуулах, гэрчийн мэдүүлэг авах, шинжээч томилуулах”, нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх болон хариуцагч тал ирээгүй /тодорхойгүй шалтгаантай/ гэсэн 3 шалтгаан эзэлж байна.

Шүүх болон хууль зүйн байгууллагуудтай холбоотой шалтгааныг харвал.

- Шүүх хурлын **9.2 хувь нь шүүх болон хууль зүйн байгууллагуудтай холбоотой асуудлаас болж хойшилсон** байна. Үүнээс хамгийн их хувийг эзэлж байгаа 3 шалтгааныг дурдвал хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдээгүй, хууль тогтоомжийн хийдэл нөлөөлсөн болон гэрчээс мэдүүлэг авуулах гэсэн байна.

Зөвхөн өмгөөлөгчтэй холбоотой шалтгааныг харвал.

- Шүүх хурлын **32.7 хувь нь өмгөөлөгчтэй холбоотой асуудлаар хойшилсон** байна. Үүнийг задалж харвал 13.3 хувь нь өмгөөлөгчийн хурал давхардсан, 11.2 хувь нь өмгөөлөгч авах хүсэлт гаргасан үлдсэн 8.2 хувь нь өмгөөлөгч өвчтэй гэсэн байна.

**Хүснэгт 3. Шүүх хурал хойшлуулах шалтгаанаас огт сонгогдоогүй шалтгаануудыг харуулав**


ЗХХШтХ-ийн 63 дугаар зүйлийн 63.6-д заасан “Зөрчлийн улмаас хэргийн оролцогч, гэрч, шинжээчийг шүүх хуралдааны танхимаас ...”

Шүүх хуралдааны техник хэрэгсэлд саатал гарсан

Хүснэгт 3-т нийт 25 нь хойшлуулах шалтгаанаас дээрх 2 шалтгааныг огт сонгоогүй болохыг харуулав.

### 1.2.2 ШҮҮХ ХУРАЛДААН ХОЙШЛОХОД ҮҮСЭХ ҮР ДАГАВРЫГ ТОДОРХОЙЛОХ

**График 13. Та шүүх хуралдааныг хойшлуулах шаардлагагүй үргэлжлүүлэх нь зөв байсан гэж бодож байсан уу?**





Шүүх хуралдааныг үргэлжлүүлэх нь зөв гэж 41 хувь нь, үгүй буюу хойшлуулах нь зөв гэж 35 хувь нь харин үлдсэн 24 нь хэлж мэдэхгүй байна гэж хариулжээ.

Шүүх хуралдааныг хойшлуулахгүйгээр үргэлжлүүлэх ёстой байсан гэж хариулсан хүмүүс дараах шалтгааныг ирүүлсэн байна. Үүнийг хүснэгт 4-т агуулгын хувьд адилхан саналын тоог нэгтгэж харуулав.

**Хүснэгт 4. Шүүх хурлыг хойшлуулах нь буруу байсан гэж хариулсан хүмүүсээс ирсэн шалтгаануудыг харуулав.**

№	Ирсэн санал	Санал хэлсэн оролцогчийн тоо
1	Илэрхий шууд шийдчих маргааныг хариуцагчийн өмгөөлөгчийн хүсэлтийг хангах байдлаар шүүгч хэт нэг талыг барьж, хариуцагч болон түүний өмгөөлөгч хугацаа хожиж, хэргийг удаашруулах санаатайгаар хойшлуулж байгаа нь нэхэмжлэгч талд алдагдсан боломжийг үүсгэсэн.	5
2	Нотлох баримт хангалттай, өмгөөлөгч авах эрх нь тухайн хүнд өөрт нь байсан гэхдээ шүүхээс нэхэмжлэл гардуулахад өмгөөлөгч авах эрхтэй гээд танилцуулдаг байх хэрэгтэй. Хэргийн оролцогч нар эрхээ эдлээд бусдад хүндрэл учруулахгүй нь тулд хурлын тов гарахаас өмнө өмгөөлөгч аваад, хэргийн материалтай танилцсан бол шүүх хурал хойшлох шаардлагагүй байсан.	3
3	Шийдвэр нь ойлгомжтой байхад хойшлуулж цаг хугацаа алдсан.	7
4	Өмгөөлөгч хурал давхардсан гэдэг нь өмнө нь залруулах, өмгөөлөгч ажлаа зохицуулах боломжтой санагдсан.	2
5	Нэхэмжлэгч тал нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөн гэсэн шалтгаанаар шүүх хурал хойшилсон. Гэвч тухайн шүүх хурлыг товлосон цагт нь эхлүүлж, хуралдаан хийж, шийдвэрлэх боломж байсан.	1
6	Шүүх хурлыг явуулах хуулийн хангалттай нөхцөл бүрдсэн байсаар байтал талуудыг мэтгэлцүүлэх зарчмаар хангах ёстой гэх үндэслэлгүй заалтаар байнга хойшлуулдаг.	1
7	ИХШХШТХ-ийн 100.3-т зааснаар хариуцагчид шүүх хуралдааны тов мэдэгдсэн боловч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол нэхэмжлэгчийн хүсэлтийн дагуу эзгүйд хэрэг хянан шийдвэрлэж болно гэтэл хариуцагчийг ирүүлнэ хэмээн хойшилсон	1
	Хэрэгт ач холбогдол бүхий бүх нотлох баримт цугларсан гэтэл хамааралгүй нотлох баримт гаргуулан хойшлуулах хүсэлт тавьсан.	1
8	Бодит байдал дээр яг болдог зүйлийг заавал хууль ийм гэж гуйвуулж олон юм шаардаж байна. Нотлох баримт хангалттай байхад олон янзаар батлахыг шаарддаг.	1

**Хүснэгт 4-т харуулсан саналаас харахад шүүх хурлыг хойшлуулахгүй үргэлжлүүлэх дараах боломжууд харагдаж байна. Эдгээр боломжуудын хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон процессыг сайжруулж болох юм. Үүнд:**

- Шүүх хуралдааны үеэр оролцогч талуудын шинээр гаргасан хүсэлтийг зарим жишиг болсон тохиолдлуудад шууд шийдвэрлэх;
- Нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөн ч тухайн нэхэмжлэлийн шаардлагыг шүүх хурал хойшлуулахгүйгээр шийдвэрлэх боломжтой байдалд үнэлгээ хийж, үнэлгээний үр дүнд хойшлуулах эсэхийг шийдвэрлэх;
- Шүүхийн байгууллага хэргийн оролцогч талуудад өмгөөлөгч авах эрхтэй гэдгийг нэхэмжлэл ирсэн дарууд сануулах мөн хууль зүйн товч мэдээллийг өгч ажилладаг байх;
- Хэргийн оролцогч нар хурлын тов гарахаас өмнө өмгөөлөгч авах асуудлыг баримтжуулж, баримт үйлдэх;
- Хурлын өмнө хэргийн зохиогч талуудтай тухайн хэргийн материалтай танилцах эсэхийг тодруулж, баталгаажуулах;



- Жишиг болсон хэрэг маргааныг хурал хойшлуулахгүйгээр шийдвэрлэдэг байх;
- Өмгөөлөгч хурал давхардахад хурлыг хойшлуулдаг асуудлыг шийдэхийн тулд технологийн аргаар өмгөөлөгчийн суух хурлын тов болон сууж буй хурлын явцыг нарийвчлан тооцож гаргадаг мэдээллийн систем болох гэх мэт гарц гаргалгааг судлах;

Дээрх судлаачийн зөвлөмжийг оролцогчдын ирүүлсэн саналд тулгуурлан гаргасан бөгөөд тус хүрээнд шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн процессыг судалж үзэн, практик дээр гарч буй асуудлыг шийдвэрлэх бодит шаардлага байсаар байна.

**График 14. Шүүх хуралдааныг хойшлуулах шаардлагагүй үргэлжлүүлэх нь зөв байсан эсэх асуумжийг судалгаанд оролцогчдын боловсролын түвшнээр харвал**



Шүүх хуралдааныг хойшлуулах шаардлагагүй үргэлжлүүлэх нь зөв байсан гэсэн асуултын хариултыг боловсролын түвшнээр харвал магистр болон түүнээс дээш, бакалаврын зэрэгтэй, тусгай дунд боловсролтой иргэдийн олонх нь зөв гэж хариулсан байна.

**График 15. Шүүх хуралдаан хойшилсноор ямар сөрөг үр дагавар үүснэ гэж Та үзэж байна вэ?<sup>11</sup>**

<sup>11</sup> **Цэнхэр өнгөөр**-Шүүх хуралд оролцогч талуудад гарах цаг хугацаа болон хөрөнгө мөнгө, эрүүл мэнд зэрэг сөрөг нөлөөг, **ногоон өнгөөр** шүүх хуралд оролцогч талууд шүүх байгууллага болон хууль эрх зүйтэй холбоотой сөрөг нөлөөг тус тус өнгөөр ялган харуулав.






График 15-аас харахад шүүх хуралдаан хойшилсноор хохирлоо төлүүлэх цаг хугацаа алдсан, олон удаа нааш цааш явж зардал их гаргасан, дараа дараагийн төлөвлөсөн ажилд сэргээр нөлөөлсөн гэх хувилбарууд нийт 15 сөрөг үр дагаврын дийлэнх хувь болох 46 хувийг эзэлж байна.


Үүнээс шүүх, хууль эрх зүйтэй холбоотой сөрөг үр дагавраас 10 хувь нь төсвийн үр ашиггүй зардал, 6 хувь нь шүүх, шүүгчийн ачаалал нэмэгдэх, 5 хувь нь шүүгчийн мэргэжлийн ур чадварт эргэлзсэн, 3 хувь нь шүүхийн бие даасан байдалд эргэлзсэн болон үлдсэн 2 хувь нь хуулийн зүйл, заалт хэрэгжээгүй гэж хариулсан байна.



## 2. ЦААСАН СУУРЬТ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Нийслэлийн төвийн дүүрэгт байрлах 7 шүүхийн Тамгын газрын шүүхийн захиргааны ажилчид шүүхээр үйлчлүүлж байсан олон нийтээс 730 иргэнийг судалгаанд хамруулсан түүврийн хэмжээг График 16-д харуулав.

**График 16. Судалгаанд оролцсон иргэдийн тоог байршлаар нь харуулав.**



Дээрх 7 нь шүүхийн Тамгын газарт хамаарах 13 шүүхээс хамгийн олон иргэнийг БЗД дэх ЭХАШШ 111 иргэнийг, Нийслэлийн ЗХАШШ 124 иргэнийг, СБД дэх ИХАШШ 182 иргэнийг хамруулсан байна.

**График 17. Тухайн шүүх хуралдаан одоогийн байдлаар хэдэн удаа хойшилсон бэ?**




График 17-оос харахад шүүхээр үйлчлүүлж байсан иргэдийн дийлэнх нь буюу 86 хувь (n=625) нь хойшилсон гэж хариулсан бөгөөд хэдэн удаа хойшилж байсныг задлан харахад 2-3 удаа хойшилсон гэсэн хариултыг хамгийн олон хүн буюу нийт оролцогчдын 35 хувь нь сонгосон бол 1 удаа хойшилсон гэсэн хариултыг 25 хувь нь хойшилж байсан гэж хариулснаас харахад онлайн судалгааны үр дүнтэй ойролцоо байна.


Жич: Цааш үргэлжлэх асуумжийн үр дүнг тооцоолохдоо нийт судалгаанд оролцсон 730 иргэнээс шүүх хурал нь хойшилж байгаагүй 95 иргэнийг хасаж 635 иргэний өгөгдөлд шинжилгээ хийх болно.



## 2.1 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Цаасан суурт судалгаанд оролцогчдийн ерөнхий мэдээллийг задлан харвал.

График 18. Судалгаанд оролцогчдын нас



Шүүхээр үйлчлүүлсэн иргэдийн дийлэнх нь 25-44 насныхан байна.

График 19. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин, эрх зүйч мэргэжилтэй эсэх болон хүйсийн харьцаа



График 19-өөс харахад судалгаанд хамрагдсан оролцогчдын 62.7 хувь нь бакалавр болон дипломын дээд боловсролтой, 19.4 хувь нь магистр болон түүнээс дээш зэрэгтэй байгаа нь хамгийн их хувийг эзэлж байна. Үүнээс харахад судалгаанд оролцож буй иргэдийн боловсролын түвшин онлайн судалгааны үр дүнтэй ойролцоо буюу харьцангуй өндөр байгааг харуулж байна.

Ажил эрхлэлтийн хувьд дийлэнх буюу 62.7 хувь нь хувийн байгууллагад, 10.4 хувь нь төрийн болон төсвийн байгууллагад ажиллаж байна.

Тус судалгаанд хүйсийн тэнцвэрт ойролцоо буюу 51 хувь нь эмэгтэй, 49 хувь нь эрэгтэйчүүд байна.


Үүнээс харахад цаасан суурт болон онлайн судалгааны оролцогчдын ерөнхий мэдээлэл ойролцоо байна.

## 2.2 ЦААСАН СУУРТ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

### 2.2.1 ШҮҮХ ХУРАЛДААН ХОЙШЛОХОД НӨЛӨӨЛЖ БУЙ ШАЛТГААН НӨХЦӨЛИЙГ ТОДОРХОЙЛОХ

Энэ бүлэгт цаасан суурт судалгааны хүрээнд шүүх хуралдаан хойшилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах байдал аль шатны, ямар төрлийн хэрэг, маргааны хувьд үүсч, хэргийн оролцогч нарт хэр их хүндрэл үүсгэдэг болохыг хэмжих болно. Мөн өмнө нь дурдсанаар эрүү, иргэн, захиргааны хэрэг маргаан нь өөр өөрийн онцлогтой байдаг тул тэдгээрийн хурал хойшлох шалтгаануудыг тус бүрээр нарийвчлан задалж харуулна.

График 20. Шүүх хуралд оролцсон талууд



Шүүхээр үйлчлүүлсэн иргэдийг шүүх хуралдаанд ямар байдлаар оролцож байсныг задлан харвал олонх нь буюу 32.9 хувь нь нэхэмжлэгч, 19.1 хувь нь итгэмжлэгдсэн төлөөлөгч, 12.8 хувь нь хариуцагч оролцсон байна.

Онлайн судалгааны хувьд өмгөөлөгч 12 хувийг эзэлж байсан бол энэхүү судалгаанд 6.3 хувийг эзэлж байна.

Үүнээс харахад нэхэмжлэгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хариуцагч болон яллагдагч, хохирогч нарын санал бодол бусад оролцогч нараас илүү тусгагдахаар харагдаж байна.

Шүүх хурал хойшилж байсан гэж хариулсан иргэдийн хувьд анхан шатны шүүх дээр хүндрэл үүсч байсан гэж тус оролцогчдын 89.8 хувь нь (n=570), 1.4 хувь нь (n=9) харин үлдсэн 8.8 хувь нь (n=56) хүндрэл үүсэж байгаагүй гэж хариулжээ.

Тэгвэл график 22-д шүүх хуралдаан хойшилж, хүндрэл үүсгэсэн эсэхийг шүүхийн шатлал болон хэрэг хянан шийдвэрлэх төрлөөр задлан харвал:

**График 21. Шүүх хурал хойшилж хүндрэл үүсгэсэн эсэхийг шүүхийн шатлал болон маргааны төрлөөр харуулав**



Шүүх хурал нь хойшилж хүндрэл үүсгэсэн гэж хариулсан 366 оролцогч иргэний хэргийн анхан шатны шүүхээр үйлчлүүлсэн байна. Харин захиргааны хэргийн анхан шатны шүүхийг хүндрэл үүсгэсэн гэж 54 иргэд, эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр үйлчлүүлсэн 144 иргэд харин зөрчлийн хэргийн 6 хүн хүндрэлтэй байдал үүсгэсэн гэжээ.

**График 22. Тухайн хэрэг маргаан нь шүүхэд хандсанаас хойш эцэслэн шийдвэрлэгдэхгүй хэр удаж байна вэ? /n=625/**




График 22-оос харахад эдгээр шүүхэд хандаж байсан оролцогчдын олонх нь буюу 28.6 хувь нь 3-5 сарын хугацаанд, 17.3 хувь нь 1-2 сарын хугацаанд, 16.5 хувь нь 1 сар хүртэл хугацаанд асуудлаа шийдвэрлүүлсэн байна.

Зөрчлийн хэргээр шүүхэд хандсан 35-44 насны эмэгтэйн шүүх хурал 2-3 удаа Өмгөөлөгч авах хүсэлт гаргасан, хэргийн зохигч сэтгэцийн болон бусад хүнд өвчний улмаас хүрэлцэн ирж чадахгүй гэсэн шалтгаанаар хурал хойшилсоор хэргийг шийдвэрлээгүй 1-2 жил болж байна гэжээ. Тухайн оролцогчийн хувьд шүүх хуралдааныг хойшлуулах үргэлжлүүлж болох байсан гэж үзсэн ба шүүх хуралд санаатай саад учруулсан гэж хариулсан байна. *(тус зөрчлийн хэргийн хувьд судалгаанд оролцогч шүүх хуралд аль талынх болох сонголтыг хийгээгүй байна.)* Тус асуумж нь судлаачийн сонирхлыг татсан бөгөөд Зөрчил хянан шийдвэрлэх хуулийн 8-р бүлгийн 8.1 дэх 8 дугаар заалтад (Зөрчлийн хэргийн ээдрээ, төвөгтэй байдлыг харгалзан зөрчлийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх хугацааг шүүгчийн саналыг харгалзан тухайн шүүхийн Ерөнхий шүүгч ажлын 2 өдрөөр нэг удаа сунгаж болно.) гэсэн байхад бодит байдал дээр хуульд зааснаас урт хугацаанд зөрчлийг хянан шийдвэрлэсэн харагдаж байна.


Зөрчлийг хянан шийдвэрлэх хугацааг судалгаанаас нарийвчлан харахад 2 зөрчлийн хэргийг 14 хоногийн дотор, 8 зөрчлийг 1 сар хүртэл хугацаанд, 3-5 сар болон 1-2 жилийн хугацаанд шийдвэрлэсэн гэж тус бүр нэг зөрчил байна.

**График 23. Шүүх хуралдаан хойшилсноор иргэдэд үүсч буй хүндрэлийг харуулав.**




Шүүх хурал хойшлох нь хэр хүндрэлтэй байдал үүсгэсэн болохыг үнэлүүлэхэд онлайн судалгаанд оролцогчдоос илүү их хүндрэл үүссэн гэж олонх нь хариулсан ба үүний 9 хувь нь маш их хүндрэл үүссэн, 44 хувь нь их хүндрэл үүссэн, 19% нь тодорхой хэмжээнд хүндрэл үүссэн гэжээ.

**График 24. Шүүх хуралдаан хойшилсноор иргэдэд үүсч буй хүндрэлийн төвшнийг хүйсээр харьцуулан харуулав.**



Шүүх хуралдаан хойшилсноор үүсэх хүндрэл бэрхшээлд хүйсийн ялгаатай байдал бий эсэхийг харьцуулан харахад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 8 хувиар илүү хүндрэл, бэрхшээл үүсдэг гэж хариулсан байна.

**График 25. Эрүүгийн хэргийн шүүх хуралдаан хойшилсон шалтгаануудыг харуулав.<sup>12</sup> (n=597 давтагдсан утга)**



Дээрх 25-р графикт эрүүгийн хэргийн шүүх хурал ямар шалтгааны улмаас хойшилсон болохыг харуулав. Нийт шалтгааны дийлэнх хувийг өмгөөлөгч авах хүсэлт гаргасан, өмгөөлөгч өвчтэй удаах нь хэргийн материалтай танилцах хүсэлт гарсан гэсэн хариултууд байна.

Нийт 25 шалтгааныг шүүх хуралд оролцогч талуудаас шалтгаалсан, шүүх болон хууль зүйн байгууллагуудтай хамааралтай болон зөвхөн өмгөөлөгчтэй холбоотой гэж 3 хэсэгт өнгөөр ялган харуулав. Үүнд:

Шүүх хуралд оролцогч талуудтай холбоотой шалтгааныг тодруулж харвал.

- Шүүх хурлын **48.1 хувь нь шүүх хуралд оролцогч талуудаас шалтгаалж хойшилсон** бөгөөд үүнээс хамгийн их хувийг эзэлж байгаа 3 шалтгааныг харвал хэргийн материалтай танилцах хүсэлт гарсан, шүүгчээс татгалзах

<sup>12</sup> **Цэнхэр өнгөөр**-Шүүх хуралд оролцогч талуудтай, **ногоон өнгөөр** шүүх болон хууль зүйн байгууллагуудтай хамааралтай харин **шар өнгөөр** зөвхөн өмгөөлөгчтэй холбоотой шалтгаануудыг тэмдэглэв.



тухай хүсэлт гаргасан болон бусад буюу өгөгдсөн шалтгаануудаас өөр шалтгааныг нэрлэсэн байна.

Шүүх болон хууль зүйн байгууллагуудтай холбоотой шалтгааныг харвал.

- Шүүх хурлын **9.2 хувь нь шүүх болон хууль зүйн байгууллагуудтай холбоотой асуудлаас болж хойшилсон** ба үүнээс хамгийн их хувийг эзэлж байгаа 3 шалтгааныг дурдвал прокурор шүүх хуралдаанд ирээгүй, шүүх хуралдааны танхим хүрэлцээгүй болон хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдээгүй гэсэн шалтгаан байна.

Зөвхөн өмгөөлөгчтэй холбоотой шалтгааныг харвал.

- Өмгөөлөгч авах хүсэлт гаргасан, өмгөөлөгч өвчтэй, өмгөөлөгч солигдож, эсхүл нэмэгдэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох болсон гэх 3 шалтгаанаар шүүх хурлын **42.7 хувь нь** хойшилдог байна.

#### Хүснэгт 5. Шүүх хурал хойшлуулах шалтгаанаас огт сонгогдоогүй шалтгаануудыг харуулав

Шүүх хуралдааны тог тасарсан (хэргийн оролцогчдын хэн нэгэн зайнаас буюу цахимаар оролцох үед)

Шинжээчийн дүгнэлт гартал түдгэлзүүлэх тухай асуудал

Судалгаанд оролцогчид нийт 27 шалтгаанаас дээрх хүснэгт 5-аар харуулсан 2 шалтгааныг огт сонгоогүй байна.


Эрүүгийн 2021-2022 онд шийдвэрлэгдсэн хэргүүдээс 12 төрлийн нийт 30 хэрэгт баримт бичгийн судалгаа хийсэн байна. Үүнээс хэрэг хянан шийдвэрлэсэн хугацааг харвал 55.3 хоногоос 147 хоногт хэргийг шийдвэрлэсэн байна. Үүнээс хамгийн их хугацаа зарцуулсан хэргийг дурдвал 27.10-2 дугаар (*Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал*) зүйчлэлтэй хэргийг дунджаар 147 хоног, 11.1-1 дүгээр зүйчлэлтэй хэргийг 119 хоногийн хугацаанд шийдвэрлэсэн байна<sup>13</sup>.

<sup>13</sup> (“Эрүү, иргэн, захиргааны хэргийн хавтаст хэрэгт хийсэн баримт бичгийн судалгааны тайлан”; Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв; Улаанбаатар-2022)





**График 26. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулсан хугацааг хэргийн зүйчлэлээр харуулав**



**График 27. Иргэний хэргийн шүүх хуралдаан хойшилсон шалтгааныг харуулав.**  
<sup>14, 15</sup>(n=925 давтагдсан утга)



<sup>14</sup> ИХШХШТХ-ийн 90 дугаар зүйлийн 90.5-д заасан үндэслэл (Зөрчлийн улмаас хэргийн оролцогч, гэрч, шинжээчийг шүүх хуралдааны танхимаас гаргасан тохиолдолд шүүх хуралдааныг хуралдаан даргалагчийн захирамжаар тодорхой хугацаагаар хойшлуулах, эсхүл тэдгээрийн тайлбар, мэдүүлгийг сонсохгүйгээр хэргийг хянан шийдвэрлэх боломжтой гэж шүүх хуралдаан даргалагч буюу шүүгч үзвэл үргэлжлүүлэн явуулна. Уг этгээд хүсвэл шүүх хуралдааны үйл ажиллагааны талаар тэмдэглэлээс танилцуулж болно.

<sup>15</sup> **Цэнхэр өнгөөр**-Шүүх хуралд оролцогч талуудтай, **ногоон өнгөөр** шүүх болон хууль зүйн байгууллагуудтай хамааралтай харин **шар өнгөөр** зөвхөн өмгөөлөгчтэй холбоотой шалтгаануудыг тэмдэглэв.





График 27-оос харахад нийт 14 шалтгаанаар иргэний хэргийн шүүх хуралдаан хойшилсон ба үүнээс өмгөөлөгч авах хүсэлт гаргасан, хэргийн материалтай танилцах хүсэлт гаргасан болон өмгөөлөгчийн хурал давхардсан гэсэн 3 шалтгаан хамгийн их хувийг эзэлж байна. Харин үүнийг шүүх хуралд оролцогч талуудаас шалтгаалсан, шүүх болон хууль зүйн байгууллагуудтай хамааралтай болон зөвхөн өмгөөлөгчтэй холбоотой гэсэн 3 хэсэгт задалж харвал. Үүнд:

Шүүх хуралд оролцогч талуудтай холбоотой шалтгааныг тодруулж харвал.

- Шүүх хурлын **52.4 хувь нь шүүх хуралд оролцогч талуудаас шалтгаалж хойшилсон** бөгөөд үүнээс хамгийн их хувийг хэргийн материалтай танилцах хүсэлт гарсан, нэхэмжлэлийн шаардлагаа нэмсэн буюу өөрчилсөн хүсэлт гаргасан болон гэрч, гуравдагч этгээд оролцуулах хүсэлт гаргасан гэсэн эдгээр шалтгаанууд эзэлж байна.

Шүүх болон хууль зүйн байгууллагуудтай холбоотой шалтгааныг харвал.

- Шүүх хурлын **4.4 хувь нь шүүх болон хууль зүйн байгууллагуудтай холбоотой асуудлаас болж хойшилсон** байна. Үүнээс хамгийн их хувийг эзэлж байгаа 3 шалтгааныг дурдвал шүүх хурлын танхим хүрэлцээгүй, шүүх хуралдааны тов мэдэгдээгүй, шүүх хуралдааны техник хэрэгсэлд саатал гарсан байна.

Зөвхөн өмгөөлөгчтэй холбоотой шалтгааныг харвал.

- Шүүх хурлын **42.6 хувь нь өмгөөлөгчтэй холбоотой асуудлаар хойшилсон** байна. Үүнийг задалж харвал 25.2 хувь нь өмгөөлөгч авах хүсэлт гаргасан, 12.1 хувь нь өмгөөлөгчийн хурал давхардсан гэсэн бол үлдсэн 5.3 хувь нь өмгөөлөгч өвчтэй гэсэн байна.

#### Хүснэгт 6. Шүүх хурал хойшлуулах шалтгаанаас зөвхөн нэг л хүн тухайн шалтгааныг сонгосон бас огт сонгогдоогүй шалтгаануудыг харуулав

ИХШХШТХ-ийн 100 дугаар зүйлийн 100.8-д заасан үндэслэл (Томилогдсон иргэдийн төлөөлөгч энэ хуулийн 76.1.2-т заасны дагуу мэдэгдсээр байхад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол зохигчийн зөвшөөрлөөр түүний эзгүйд шүүх хуралдаан явуулж болно. Харин зохигчийн аль нэг нь үүнийг зөвшөөрөөгүй бол шүүх хуралдааныг хойшлуулна.) /Огт сонгогдоогүй шалтгаан/

Шүүгч өөрөө татгалзан гарах тухай хүсэлт гаргасан

Гэрлэгчдийн хэн нэг нь хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй

Шүүх хуралдааны тог тасарсан (хэргийн оролцогчдын хэн нэгэн зайнаас буюу цахимаар оролцох үед)

Хурлын үеэр хуралд оролцогчдын нэгнийхэн бие муудсан

Хууль тогтоомжийн хийдэл нөлөөлсөн

Бусад

Харин нийт 21 нь хойшлуулах шалтгаанаас дараах шалтгаануудыг огт сонгоогүй болон зөвхөн нэг оролцогч сонгосон 7 шалтгааныг дээрх хүснэгт 6-аар харуулав.

#### График 28. Захиргааны хэргийн шүүх хуралдаан хойшилсон шалтгааныг харуулав.

<sup>16, 17</sup>(n=416 давтагдсан утга)




График 28-аас харахад захиргааны хэргийн шүүх хуралдаан хойшилсон 19 шалтгаанаас өмгөөлөгч авах хүсэлт гаргасан, өмгөөлөгчийн хурал давхацсан болон хэргийн материалтай танилцах хүсэлт гаргасан гэсэн хариултууд хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Харин үүнийг шүүх хуралд оролцогч талуудаас шалтгаалсан, шүүх болон хууль зүйн байгууллагуудтай хамааралтай болон зөвхөн өмгөөлөгчтэй холбоотой гэсэн 3 хэсэгт задалж харвал. Үүнд:

<sup>16</sup> ЗХХШТХ-ийн 74 дүгээр зүйлийн 74.2-т заасан "...нэмэлт нотлох баримт цуглуулах, гэрчийн мэдүүлэг авах, шинжээч томилуулах",  
<sup>17</sup> ЗХХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.7-д заасан "...шинээр нотлох баримт зайлшгүй шаардагдвал",  
 ЗХХШТХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.2-т заасан "Нэхэмжлэгч, түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч шүүх хуралдаанд ирээгүй".

<sup>17</sup> **Цэнхэр өнгөөр**-Шүүх хуралд оролцогч талуудтай, **ногоон өнгөөр** шүүх болон хууль зүйн байгууллагуудтай хамааралтай харин **шар өнгөөр** зөвхөн өмгөөлөгчтэй холбоотой шалтгаануудыг тэмдэглэв.

Шүүх хуралд оролцогч талуудтай холбоотой шалтгааныг тодруулж харвал.

- Шүүх хурлын **56.7 хувь нь шүүх хуралд оролцогч талуудаас шалтгаалж хойшилсон** бөгөөд үүнээс хамгийн их хувийг хэргийн материалтай танилцах, хариуцагч тал ирээгүй /тодорхойгүй шалтгаантай/, шинжээч томилох, нотлох баримт цуглуулах гэсэн 3 шалтгаан эзэлж байна.

Шүүх болон хууль зүйн байгууллагуудтай холбоотой шалтгааныг харвал.

- Шүүх хурлын **1.2 хувь нь шүүх болон хууль зүйн байгууллагуудтай холбоотой асуудлаас болж хойшилсон** ба хэргийн оролцогчдод шүүх хуралдааны тов мэдэгдээгүй гэсэн байна.

Зөвхөн өмгөөлөгчтэй холбоотой шалтгааныг харвал.

- Шүүх хурлын **41.1 хувь нь өмгөөлөгчтэй холбоотой асуудлаар хойшилсон** байна. Үүнийг задалж харвал 18.5 хувь нь өмгөөлөгч авах хүсэлт гаргасан, 14.4 хувь нь өмгөөлөгчийн хурал давхардсан үлдсэн 8.2 хувь нь өмгөөлөгч өвчтэй гэсэн байна.


#### Хүснэгт 7. Шүүх хурал хойшлуулах шалтгаанаас зөвхөн нэг л хүн тухайн шалтгааныг сонгосон бас огт сонгогдоогүй шалтгаануудыг харуулав

Шүүх хуралдааны техник хэрэгсэлд саатал гарсан /огт сонгоогүй/
Хурлын үеэр хуралд оролцогчдын нэгнийхэн бие муудсан /огт сонгоогүй/
Шүүгч өөрөө татгалзан гарах тухай хүсэлт гаргасан
ЗХХШТХ-ийн 63 дугаар зүйлийн 63.6-д заасан “Зөрчлийн улмаас хэргийн оролцогч, гэрч, шинжээчийг шүүх хуралдааны танхимаас ...”
Шүүх хурлын танхим хүрэлцээгүй
Хууль тогтоомжийн хийдэл нөлөөлсөн
Шүүх хуралдааны техник хэрэгсэлд саатал гарсан

Харин нийт 26 нь хойшлуулах шалтгаанаас дараах шалтгаануудыг огт сонгоогүй болон зөвхөн нэг оролцогч сонгосон 7 шалтгааныг дээрх хүснэгт 7-д харуулав.

## 2.2.2 ШҮҮХ ХУРАЛДААН ХОЙШЛОХОД ҮҮСЭХ ҮР ДАГАВРЫГ ТОДОРХОЙЛОХ

**График 29. Та шүүх хуралдааныг хойшлуулах шаардлагагүй үргэлжлүүлэх нь зөв байсан гэж бодож байсан уу?**



Шүүх хуралдааныг үргэлжлүүлэх нь зөв гэж 23 хувь нь, үгүй буюу хойшлуулах нь шаардлагатай байсан гэж 58 хувь нь харин үлдсэн 19 нь хэлж мэдэхгүй байна гэж хариулжээ.

Шүүх хуралдааныг хойшлуулахгүйгээр үргэлжлүүлэх ёстой байсан гэж хариулсан хүмүүсээс 82 санал ирсэн бөгөөд үүнийг хүснэгт 8 болон 9-д агуулгын хувьд адилхан саналын тоог нэгтгэж харуулав.

**Хүснэгт 8. Шүүх хурлыг хойшлуулах нь буруу байсан гэж хариулсан хүмүүсээс ирсэн хэргийн оролцогч, өмгөөлөгч нарыг буруутгасан болон бусад шалтгаануудыг харуулав.**

№	Ирсэн санал	Санал хэлсэн оролцогчийн тоо
1	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагч тал санаатай саад учруулсан гэж бодсон.	29
2	Шүүх хуралдаанд хариуцагч, нэхэмжлэгч, иргэдийн төлөөлөгч болон өмгөөлөгч нар шүүх хурлын товыг мэдсээр байж ирээгүй нөхцөл байдал үүссэн хэдий ч хэрэг маргааны хувьд асуудал тодорхой учраас хурлыг үргэлжлүүлэх боломжтой байсан.	14
3	Хүндэтгэн үзэх шалтгаанаа нотолж чадаагүй байхад хурал хойшилсон.	6
4	Өмгөөлөгч нарт хэргийн материалтай танилцах хангалттай хугацаа байхад хурал дээр хэргийн материалтай танилцах хүсэлт гаргадаг нь зүйд нийцэхгүй гэж үзэж байна.	4
5	Өмгөөлөгч авах хүсэлтийг хурал зарлагдахаас өмнө гаргах хэрэгтэй.	3
6	Шүүх хуралдааны өмнө хүсэлт гаргах боломж байхад хурал дээр гаргаж байна.	3
7	Шүүх хуралд гэрч оролцох шаардлагагүй байхад гэрчийг дуудан ирүүлэхээр хурал хойшилсон.	2
8	Нэхэмжлэгч тал янз бүрийн шалтгаан хэлж ХХША-г зориуд удаашруулж, санаатай саад учруулдаг.	2
9	Хэрэг маргаан нь их энгийн шалтгаантай байхад итгэмжлэл буруу, өмгөөлөгч олдохгүй байна гэсэн шалтгаанаар хурал хойшилсон.	1
10	Нэхэмжлэлийн шаардлага хариуцагчийн тайлбараас хальж нотлох баримт гаргуулах хүсэлтийг авах шаардлагагүй байсан.	1
11	Засгийн газартай холбоотой асуудалд ажиллагаа хийсэн тохиолдолд хурал хойшилж, удаашрах шинжтэй байдаг.	1

12	Хариуцагч тайлбараа өгөхгүй удсан шалтгаанаар шүүх хурал хойшилсон.	1
13	Хуульд нийцээгүй үндэслэлээр шүүгчээс татгалзах хүсэлт гаргасан.	1

**Хүснэгт 9. Шүүх хурлыг хойшлуулах нь буруу байсан гэж хариулсан хүмүүсээс шүүгчийг илт буруутгасан шалтгаануудыг харуулав.**


№	Ирсэн санал	Санал хэлсэн оролцогчийн тоо
1	Шүүхэд гаргасан хүсэлт тухайн хэргийг шийдэхэд ач холбогдолгүй байхад хурлыг хойшлуулсан.	3
2	Шүүгч хэрэг маргаанд ач холбогдолгүй нотлох баримт шаардсан.	3
3	Шүүгч хариуцагч тал мөнгөн дүнг хүлээн зөвшөөрсөн байхад шүүх хурлыг хойшлуулсан.	1
4	Шинжээч томилох шаардлага үүсээгүй байхад тус шалтгааны улмаас шүүх хурал хойшилсон.	1
5	Өмгөөлөгч хэргийн материалтай танилцах хугацааг тулгадаг мөн шүүгч нар өмгөөлөгчтэй хуйвалдаж хариуцагчийн талд үйлчилж, нэхэмжлэлийг хүлээн авдаггүй.	1
6	Гарын үсгийн шинжээч томилох огт шаардлагагүй байхад томилолтоор ирсэн шүүгч илт үндэслэлгүй хурал хойшлуулж байсан. Энэ хурал 2 дахь жилээ сунжирч байна.	1
7	Шүүхийн зүгээс шаардлагатай ажиллагааг цаг тухайд нь хийгээгүй.	1
8	Хууль зүйн үндэслэл бүрдээгүй байхад шүүгч хойшлуулдаг.	1
9	Шүүгч 1 үндэслэлээр 2 удаа хурлыг хойшлуулсан.	1
10	Бага дүнтэй нэхэмжлэл байхад хурлыг хойшлуулсан нь төвөгтэй байдал үүсгэсэн.	1

**График 30. Шүүх хуралдааныг хойшлуулах шаардлагагүй үргэлжлүүлэх нь зөв байсан эсэх асуумжийг судалгаанд оролцогчдын боловсролын түвшнээр харвал**




График 30-аас харахад шүүх хуралдааныг хойшлуулах шаардлагагүй үргэлжлүүлэх нь зөв байсан эсэх асуумжийг судалгаанд оролцогчдын боловсролын түвшнээр харвал онлайн судалгааны үр дүнгээс ялгаатай буюу магистр болон түүнээс дээш, бакалаврын зэрэгтэй, тусгай дунд боловсролтой иргэдийн олонх нь хойшлуулсан нь зөв гэж хариулсан байна.

**График 31. Шүүх хуралдааныг хойшлуулах шаардлагагүй үргэлжлүүлэх нь зөв байсан эсэх асуумжийг судалгаанд оролцогчдын хүйсээр харвал**



Мөн тус асуултын хувьд эрэгтэйчүүдийн 55 хувь нь шүүх хурлыг хойшлуулсан нь зөв гэж хариулсан бол эмэгтэйчүүдийн 61 хувь нь мөн адил хариулсан байна.

**График 32. Шүүх хуралдааныг хойшлуулах шаардлагагүй үргэлжлүүлэх нь зөв байсан эсэх асуумжийн хувилбар тус бүрийг хүйсээр харвал**



Харин хариулт тус бүрээр харьцуулж харахад тийм зөв гэж хариулсан хүмүүсийн олонх нь эрэгтэй, үргэлжлэх нь буруу гэж хариулсан хүмүүсийн дийлэнх нь эмэгтэйчүүд байсан бол эмэгтэйчүүдийн дийлэнх нь хэлж мэдэхгүй гэж хариулсан байна.

**График 33. Шүүх хуралдаан хойшилсноор ямар сөрөг үр дагавар үүснэ гэж Та үзэж байна вэ?<sup>18</sup>**

<sup>18</sup> **Цэнхэр өнгөөр**-Шүүх хуралд оролцогч талуудад гарах цаг хугацаа болон хөрөнгө мөнгө, эрүүл мэнд зэрэг сөрөг нөлөөг, **ногоон өнгөөр** шүүх хуралд оролцогч талууд шүүх байгууллагад гарах болон хууль эрх зүйтэй холбоотой сөрөг нөлөөг тус тус өнгөөр ялган харуулав.




График 33-аас харахад шүүх хуралдаан хойшилсноор хохирлоо төлүүлэх цаг хугацаа алдсан, олон удаа нааш цааш явж зардал их гаргасан, дараа дараагийн төлөвлөсөн ажилд сэргээр нөлөөлсөн гэх хувилбарууд нийт 15 сөрөг үр дагаврын дийлэнх хувь болох 67.9 хувийг эзэлж байгаа бөгөөд онлайн судалгааны үр дүнтэй ижил байна. Үүнээс шүүхтэй шууд холбоотой байж болох сөрөг үр дагаврын 2.2 хувь нь шүүгчийн бие даасан байдалд эргэлзсэн, 1.7 хувь нь шүүх, шүүгчийн ачаалал нэмэгдэх, 1.7 хувь нь шүүгчийн мэргэжлийн ур чадварт эргэлзсэн гэж хариулсан байна.

2022 оны “Эрүү, иргэн, захиргааны хэргийн хавтаст хэрэгт хийсэн баримт бичгийн судалгааны тайлан”-аас Захиргааны хэргийн 128/2018/0106/з дугаартай 2017 оны 12-р сарын 22-н өдөр ирсэн нэхэмжлэлд холбогдох хэргийг 2018 оны 12-р сарын 06-ны өдөр эцэслэн шийдвэрлэсэн байна. Тус хэрэг нь газрын маргаан бөгөөд анхан шатны шүүх дээр эцэслэн шийдвэрлэгдсэн байна. Хэргийг шийдвэрлэхэд **58 хоног зарцуулсан** бөгөөд хавтаст хэрэгт 105 ажиллагаа бүртгэгдсэн ба **17 удаа шүүх хуралдааныг хойшлуулсан** байна. Тухайн хэргийн хэрэг хянан шийдвэрлэх явцад хийгдсэн ажиллагааны жагсаалтыг хавсралт 1-ээс харна уу.



## ДҮГНЭЛТ

Шүүхийн байгууллагын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанарыг хэмжих нэгэн хэмжүүр бол хэргийг шийдвэрлэж буй хугацаа юм. Уг хугацаа нь шүүх хурал хэдэн удаа хойшлохоос шууд хамааралтай боловч хэргийг хянан шийдвэрлэх явцад хэргийн ээдрээ төвөгтэй байдал, хэргийн оролцогчийн тоо олон байх зэрэг нөхцөл байдлаас болж шүүх алдаа мадаггүй шийдвэр гаргахын тулд олон дахин хойшлох тохиолдол гарах нь зүй ёсны асуудал юм.

Гэхдээ зарим тохиолдолд шүүхийн шийдвэр удааширч байгаа нь шүүх процесст алдаа байхыг үгүйсгэхгүй юм.

Мөн иргэдийн дунд шүүхэд хандаж асуудлаа шийдвэрлүүлэх хэрэгцээ байвч тухайн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах хугацаа болон бусад нөхцөл байдлыг үнэлснээр асуудлыг орхиж, тухайн асуудал нь хууль зөрчиж буй зарим этгээдийг өөгшүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Мөнгө санхүүтэй холбоотой маргааны хувьд шүүхийн журмаар зээл, авлагаас төлүүлсэн дүнгээс шүүхийн бус журмаар төлүүлсэн дүн нь харьцангуй бага боловч, хугацааны хувьд авч үзвэл бараг хоёр дахин бага (6.2/3.4 жил) хугацаа зарцуулжээ. Шүүхийн журмаар барагдуулсан активт зарцуулсан хугацаа хамгийн бага нь 134 хоног, хамгийн их нь 16.6 жил байсан бол шүүхийн бус журмаар барагдуулсан активт зарцуулсан хугацаа хамгийн багадаа нэг хоног, хамгийн уртдаа 12.7 жил байна.<sup>19</sup>

Үүнээс харахад бизнесийн орчны хувьд харилцагч талууд гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолуудын тоо нэмэгдэхийн хэрээр итгэлцэл буурах үзэгдэл бий болж эдийн засгийн хувьд таагүй байдал үүснэ.

Энэ асуудал нь нийгмийн хэсэг бүлэгт Девиаци<sup>20</sup> (гажилт) үзэгдлийг бий болгох магадлалтай харин шүүхийн хувьд зардлыг нэмэгдүүлэх сөрөг талтай учир шүүхийн байгууллага боломжит түргэн шуурхай шийдвэрлэх арга замыг эрэлхийлж байна.

Иймд энэхүү асуудлын хүрээнд шүүх хуралдаан хойшилж, удааширдаг шалтгаан нөхцөлийг илрүүлж, түүнээс үүсэх үр дагавар хэргийн оролцогч нарт ямар хүндрэл бэрхшээл учруулдаг болохыг тодорхойлж уг хүндрэл бэрхшээлийг бууруулах зорилготойгоор хийсэн судалгааны үр дүнг танилцуулъя.

Онлайн болон цаасан суурьт анкетаар буюу 2 өөр арга зүйгээр мэдээлэл цуглуулсан судалгаанд нийт 836 иргэн оролцож үүнээс 25-44 насны иргэд дийлэнх хувийг эзэлж байна. Боловсролын хувьд аль аль судалгаанд 60 буюу 60 дээш хувь нь бакалавр болон дипломын дээд боловсролтой бол 19.4-24 хувь нь магистр болон түүнээс дээш зэрэгтэй байгаа нь судалгаанд оролцож буй иргэдийн боловсролын түвшин харьцангуй өндөр байв.

Ажил эрхлэлтийн хувьд олонх нь хувийн байгууллагад болон төрийн болон төсвийн байгууллагад ажилладаг ба хүйсийн тэнцвэрт байдал сайн хангагджээ.

<sup>19</sup> “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл, 2020 оны 21-р дугаар, “Чанаргүй зээлийн барагдуулалт /Хадгаламж банк ХХК-ийн жишээ”, хуудас-50.

<sup>20</sup> Нийгмийн олонх нь хүлээн зөвшөөрсөн, байж байгаа хэм хэмжээ буюу хэм хэмжээний цогцтой үл нийцэх явдлыг хэлнэ.





Шүүхээр үйлчлүүлсэн иргэдийг шүүх хуралдаанд ямар байдлаар оролцож байсныг задлан харвал олонх нь нэхэмжлэгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч болон хариуцагч оролцсон байна.

Шүүх хуралдаан хойшлоход нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг тодорхойлох зорилтын хүрээнд:

- Шүүх хурал дор хаяж 2-3 удаа хойшлох магадлал өндөр бөгөөд шүүх хурал хойшилсноор хүндрэл үүссэн гэж 87.5 хувь нь үзсэн байна. Ихэвчлэн анхан шатны иргэний хэрэг дээр хүндрэл үүсдэг байна.
- Хэрэг хянан шийдвэрлэх хугацааны хувьд дийлэнх иргэд хэрэг маргаанаа 1-5 сарын хугацаанд асуудлаа шийдвэрлүүлж байна.
- Шүүх хуралдаан хойшилсноор онлайн судалгаанд оролцогчийн 34 хувь нь, цаасан судалгаанд оролцогчдын 53 хувь нь маш их болон нэлээн хүндрэл үүсгэсэн гэжээ.
- Эрүү, иргэн, захиргааны хэргийн төрлөөс үл хамааран өмгөөлөгч авах хүсэлт гаргасан, өмгөөлөгч өвчтэй, хэргийн материалтай танилцах хүсэлт гаргасан болон өмгөөлөгчийн хурал давхацсан гэсэн шалтгаанаар ихэнх хурлууд хойшилж байна.
- Мөн шүүх хурлын 48.1-56.7 хувь нь хэргийн оролцогч талуудаас хамаарч байгаа бол 41.1-42.7 хувь нь өмгөөлөгчтэй холбоотой асуудлаас харин 1.2-9.2 хувь нь шүүх болон хууль зүйн байгууллагууд хамааралтай асуудлаас болж хойшилж байна.

Шүүх хуралдаан хойшлоход үүсэх үр дагаврыг тодорхойлох зорилтын хүрээнд:

- Онлайн судалгааны хувьд олонх нь шүүх хуралдааныг үргэлжлүүлэх нь зөв гэсэн бол харин цаасан суурьт судалгааны хувьд хойшлуулах нь зөв байсан гэжээ.
- Тийм зөв гэж хариулсан хүмүүсийн олонх нь эрэгтэйчүүд харин үргэлжлэх нь буруу гэж хариулсан хүмүүсийн дийлэнх нь эмэгтэйчүүд байв.
- Шүүх хуралдаан хойшилсноор хохирлоо төлүүлэх цаг хугацаа алдсан, олон удаа нааш цааш явж зардал их гаргасан, дараа дараагийн төлөвлөсөн ажилд сөргөөр нөлөөлсөн гэх хувилбарууд нийт 15 сөрөг үр дагаврын дийлэнх хувь болох 67.9 хувийг эзэлж байгаа бөгөөд онлайн судалгааны үр дүнтэй ижил байна. Үүнээс шүүхтэй шууд холбоотой байж болох сөрөг үр дагаврын 2.2 хувь нь шүүгчийн бие даасан байдалд эргэлзсэн, 1.7 хувь нь шүүх, шүүгчийн ачаалал нэмэгдэх, 1.7 хувь нь шүүгчийн мэргэжлийн ур чадварт эргэлзсэн байна.

## ЗӨВЛӨМЖ

Судалгааны хүрээнд шүүх хурлыг хойшлуулахгүй үргэлжлүүлэх дараах боломжууд харагдаж байна. Эдгээр боломжуудын хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон процессыг сайжруулж болох юм.

- Шүүх хуралдааны үеэр оролцогч талуудын шинээр гаргасан хүсэлтийг зарим жишиг болсон тохиолдлуудад шууд шийдвэрлэх;
- Хэрэг хянан шийдвэрлэх хугацаанд хүсэлт, тайлбар нэмэгдсэн тохиолдолд тодорхой хэмжээний төлбөр төлдөг болгох;
- Нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөн ч тухайн нэхэмжлэлийн шаардлагыг шүүх хурал хойшлуулахгүйгээр шийдвэрлэх боломжтой байдалд үнэлгээ хийж, үнэлгээний үр дүнд хойшлуулах эсэхийг шийдвэрлэх;
- Шүүхийн байгууллага хэргийн оролцогч талуудад өмгөөлөгч авах эрхтэй гэдгийг нэхэмжлэл ирсэн дарууд сануулах мөн хууль зүйн товч мэдээллийг өгч ажилладаг байх;
- Хэргийн оролцогч нар хурлын тов гарахаас өмнө өмгөөлөгч авах асуудлыг баримтжуулж, баримт үйлдэх;
- Хурлын өмнө хэргийн зохиогч талуудтай тухайн хэргийн материалтай танилцах эсэхийг тодруулж, баталгаажуулах;
- Жишиг болсон хэрэг маргааныг хурал хойшлуулахгүйгээр шийдвэрлэдэг байх;
- Өмгөөлөгч хурал давхардахад хурлыг хойшлуулдаг асуудлыг шийдэхийн тулд технологийн аргаар өмгөөлөгчийн суух хурлын тов болон сууж буй хурлын явцыг нарийвчлан тооцож гаргадаг мэдээллийн системтэй болох;
- Хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг илүү боловсронгуй болгох;
- Онцгой ажиллагааны журмаар гаргасан хүсэлтийг шүүх хуралдаан хийхгүйгээр шийдвэрлэх.
- Хэрэв шүүх хурлыг хойшлуулах нөхцөл байдал үүсэхэд тодорхой хэмжээний төлбөр төлөх системтэй болох гэх мэт гарц гаргалгааг судлах шаардлагатай байна.

Дээрх судлаачийн зөвлөмжийг оролцогчдын ирүүлсэн саналд тулгуурлан гаргасан бөгөөд тус хүрээнд шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн процессыг судалж үзэн, практик дээр гарч буй асуудлыг шийдвэрлэх бодит шаардлага байсаар байна.

**Хавсралт1.**

Захиргааны хэргийн 128/2018/0106/з дугаартай газрын маргаан нь анхан шатны шүүх дээр эцэслэн шийдвэрлэгдсэн байна. Хэргийг шийдвэрлэхэд 58 хоног зарцуулсан бөгөөд хавтаст хэрэгт 105 ажиллагаа бүртгэгдсэн байв.

№	Баримтын нэр	Огноо
1	Нэхэмжлэл	2017.12.22
2	Захирамж-Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох	2017.12.28
3	Баримт-гардуулсан	2018.01.03
4	Нэхэмжлэл	2018.01.09
5	Захирамж-Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулах хугацаа тогтоох	2018.01.17
6	Баримт-гардуулсан	2018.01.19
7	Нэхэмжлэл	2018.01.25
8	Захирамж-хэрэг үүсгэх	2018.02.01
9	Баримт-Шүүхэд дуудан ирүүлэх	2018.02.01
10	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2018.02.05
11	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2018.02.05
12	Баримт-Нөлөөллийн мэдүүлэг танилцуулсан	2018.02.05
13	Захирамж- Гуравдагч этгээдээр татан оролцуулах	2018.02.26
14	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2018.02.28
15	Албан бичиг	2018.03.01
16	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2018.03.21
17	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2018.03.21
18	Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол-XXШХ-г сунгах	2018.04.02
19	Албан бичиг	2018.04.23
20	Баримт-гардуулсан	2018.04.24
21	Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол-XXШХ-г сунгах	2018.04.30
22	Баримт-Урьдчилсан хэлэлцүүлгийн тов	2018.05.04
23	Тэмдэглэл-Урьдчилсан хэлэлцүүлэг	2018.05.09
24	Захирамж-Шүүх хуралдаан товлон зарлах	2018.05.09
25	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.05.09
26	Захирамж-даргалагч шүүгчийг албажуулах	2018.05.14
27	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.05.23
28	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.05.28
29	Баримт-Хэрэг танилцуулсан	2018.06.06
30	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.06.06
31	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.06.06
32	Албан бичиг	2018.06.07
33	Албан бичиг	2018.06.07
34	Албан бичиг	2018.06.07
35	Шүүх хуралдааны тэмдэглэл	2018.06.13
36	Захирамж-шүүх хуралдааныг хойшлуулах	2018.06.13
37	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.06.13
38	Албан бичиг	2018.06.20
39	Захирамж- Гуравдагч этгээдээр татан оролцуулах	2018.06.26
40	Албан бичиг	2018.06.27
41	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.06.27



42	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.06.27
43	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2018.07.03
44	Баримт-Нэхэмжлэлийн хувийг гардуулсан	2018.07.03
45	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.07.17
46	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.07.17
47	Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол-Хэрэг, нэхэмжлэл шилжүүлэх	2018.07.30
48	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.07.31
49	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.07.31
50	Баримт-Хэрэг танилцуулсан	2018.08.07
51	Албан бичиг	2018.08.09
52	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.08.13
53	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.08.13
54	Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол-Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдлыг буцаан шилжүүлэх	2018.08.13
55	Албан бичиг	2018.08.22
56	Албан бичиг	2018.08.25
57	Албан бичиг	2018.08.25
58	Баримт-хэргийн материал танилцуулсан	2018.08.27
59	Шүүх хуралдааны тэмдэглэл	2018.08.27
60	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.08.27
61	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.08.27
62	Баримт-Гэрч шинжээч, орчуулагч, хэлмэрчид эрх, үүрэг тайлбарласан	2018.08.31
63	Шүүх хуралдааны тэмдэглэл	2018.08.31
64	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.08.31
65	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.08.31
66	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.09.11
67	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.09.13
68	Баримт-Хэрэг танилцуулсан	2018.09.25
69	Шүүх хуралдааны тэмдэглэл	2018.09.25
70	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.09.25
71	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.09.25
72	Албан бичиг	2018.09.26
73	Баримт-хэргийн оролцогчид эрх, үүрэг тайлбарласан	2018.10.02
74	Баримт-Хэрэг танилцуулсан	2018.10.02
75	Шүүх хуралдааны тэмдэглэл	2018.10.02
76	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.10.02
77	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.10.02
78	Албан бичиг	2018.10.09
79	Албан бичиг	2018.10.09
80	Тэмдэглэл-Утсаар ярьсан	2018.10.10
81	Шүүх хуралдааны тэмдэглэл	2018.10.16
82	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.10.16
83	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.10.16
84	Ерөнхий шүүгчийн захирамж-Шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг хэрэгсэхгүй болгох	2018.10.16
85	Баримт-гардуулсан	2018.10.22
86	Баримт-Шүүх хуралдаанд дуудан ирүүлэх	2018.10.22
87	Шүүх хуралдааны тэмдэглэл	2018.10.22
88	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.10.22
89	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.10.22



90	Албан бичиг	2018.10.24
91	Албан бичиг	2018.10.24
92	Шүүх хуралдааны тэмдэглэл	2018.10.29
93	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.10.29
94	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.10.29
95	Албан бичиг	2018.11.01
96	Тэмдэглэл-Үзлэг хийсэн	2018.11.01
97	Шүүх хуралдааны тэмдэглэл	2018.11.01
98	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.11.01
99	Баримт-Шүүх хуралдааны товыг мэдэгдсэн	2018.11.01
100	Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол-Хэрэг, нэхэмжлэл шилжүүлэх	2018.11.12
101	Захирамж-Шүүх хуралдааныг хойшлуулах	2018.11.15
102	Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол-Хэрэг, нэхэмжлэл шилжүүлэх	2018.11.27
103	Баримт-Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын үр дагаврыг тайлбарласан	2018.11.27
104	Захирамж-Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох	2018.11.27
105	Баримт-гардуулсан	2018.12.06

